



ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ДОА-2020/1/СТА-ОНТС

Цахим хуудас: www.audit.mn Чойбалсан хот 2020 он	Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга бөгөөд Тэргүүлэх аудитор: Б.Болортуул Утас: 70584203 Цахим хаяг: Bolortuulb@audit.gov.mn Аудитын менежер: В.Цэнгэлмаа Утас: 70584204 Цахим хаяг: Tsengelmaav@audit.gov.mn Аудитор: Б.Одхүү Утас: 70584207 Цахим хаяг: Odkhuu@audit.gov.mn
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ЗГТС	Засгийн газрын тусгай сан
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ДОА	Дорнод аймаг
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан



Агуулга

Аудитын гэрчилгээ	3
2.1. Оршил	5
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	5
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	5
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	6
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	6
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	6
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	6
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	7
2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	8
2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	8
2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	9
2.12. Шилэн дансны мэдээлэл	9
2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт	9
2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	9
Менежментийн захидал	10
Аудит хийгдсэн санхүүгийн тайлан	12
4.1. Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан	12
4.2. Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	12
4.3. Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан	14
4.4. Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө /өмчийн өөрчлөлтийн тайлан	15
4.5. Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	16



ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

21000, Дорнод аймаг, Хэрлэн сум 7-р баг
ЗДТГ-ын II байр, Утас/Факс: 7058-4203

2020.02.27 № 149

танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорнод аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Дорнод аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Дорнод аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

110520152



Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.БОЛОРТУУЛ



2.1. Оршил

Аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Дорнод аймгийн Засаг дарга М.Бадамсүрэн танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэн үйлчлүүлэгчийн санхүүгийн програм ашиглах талаарх зөвлөмжийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 02 дугаар сарын 17-ноос 2020 оны 02 дугаар сарын 25-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 02 дугаар сарын 27-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, аудитор Б.Одхүү хариуцаж хэрэгжүүлэв.

Аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт 2020 оны 01 дүгээр сарын 21-ний өдрийн 1/131 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторов баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.



2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны эрхэм зорилго нь “Орон нутгийн иргэдийн тогтвор суурьшилтай амьдрал, иргэдийн аж байдалд эерэг таатай нөлөөлөл бий болгох, ээлтэй орчин бүрдүүлэхэд оршино” гэж тодорхойлсон.

Аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Улсын төсвөөс орон нутгийн хөгжлийг дэмжих зорилгоор хуваарилагдах хөрөнгийг нутгийн засаг захиргаа иргэд, олон нийтийн оролцоотой хамтын шийдвэрээр ил тод, хариуцлагатай захиран зарцуулах нөхцөлийг бүрдүүлж төсөл, хөтөлбөр, арга хэмжээг хэрэгжүүлэх, хянах, тайлагнах, орон нутгийн чадавхтай уялдуулсан олон талын харилцааг зохицуулахад оршино.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй байна.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Аймгийн Орон нутгийн хөгжлийн сан нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд программ хангамж ашигладаггүй байна.

Аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 15 эрсдэлтэй асуудалд 15 горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 1,983,611.0 мянган төгрөгөөс тооцон 39,672.2 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.



Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 108,311.1 мянган төгрөгөөр тооцсон нь 2019 онд сангийн эх үүсвэр өссөнтэй холбоотой болно.

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 475,854.7 мянган төгрөгөөр буюу 307.0 хувиар өссөн байна. Мөнгөн хөрөнгө болон авлагын дансанд өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	154,981.1	1,535.8	-153,445.3
Авлага		629,300.0	629,300.0
Урьдчилгаа			
Бараа материал			
Үндсэн хөрөнгө			
Нийт хөрөнгө	154,981.1	630,835.8	475,854.7
Өр төлбөр		379,291.3	379,291.3
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/			
Өмнөх үеийн үр дүн	154,981.1	154,981.1	
Тайлангийн үеийн үр дүн		96,563.4	96,563.4
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	154,981.1	630,835.8	475,854.7

Авлага дансны үлдэгдэл өссөн нь уул уурхай эрхэлдэг компаниудаас авах авлагыг бүрэн аваагүйгээс шалтгаалжээ. Энэ нь тайлант онд Ашигт малтмалын тухай хуулийн дагуу гэрээ байгуулсан уул уурхайн үйл ажиллагаа эрхэлдэг компаниудаас ОНХС-нд төвлөрүүлэх эх үүсвэрийн 22,0 хувь буюу 629,300.0 мянган төгрөгийг төвлөрүүлээгүйтэй холбоотой байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл өссөн нь ОНХС-гийн санхүүжилт бүрэн орж ирээгүйгээс шалтгаалжээ. Энэ нь тайлант онд хийгдсэн 379,291.3 мянган төгрөгийн төсөл арга хэмжээний санхүүжилтийг дутуу олгосонтой холбоотой байна.

2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Орон нутгийн 2019 оны батлагдсан төсөвт тусгаснаар аймгийн ОНХС нь тайлант онд 5,814,400.0 мянган төгрөгийн орлого төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 4,871,264.8 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 83,8 хувиар биелүүлсэн байна.

Хүснэгт 2. Төвлөрүүлэх орлого

/мянган төгрөг/

Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Орон нутгийн нэгдсэн сангаас санхүүжих	2,825,369.6	2,638,704.9	186,664.7	6,6



Орон нутгийн төсвөөс	25,580.4	25,580.4	0	
Хандив тусламж	2,963,450.0	2,218,534.2	744,915.8	25,0
Нийт дүн	5,814,400.0	4,882,819.5	931,580.5	31,6

Орон нутгийн нэгдсэн сангаас санхүүжих орлого 186,664.7 мянган төгрөгөөр тасарсан нь санхүүжилт дутуу төвлөрснөөс шалтгаалсан байна. Хандив тусламжийн орлого 744,915.8 мянган төгрөгөөр тасарсан нь орон нутгийн компаниудтай гэрээ байгуулаагүйгээр 115,615.8 мянган төгрөгийг төсөвт тусгасан, гэрээ байгуулсан ч 629,300.0 мянган төгрөгийг төвлөрүүлээгүйтэй холбоотой байна.

Тайлант онд Төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрт зориулан 5,814,400.0 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 165,000.0 мянган төгрөгийг урсгал зардалд, 5,649,400.0 мянган төгрөгийг хөрөнгийн зардалд зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 25,580.4 мянган төгрөгийг улсын орон нутгийн төсвөөс, 2,825,369.6 мянган төгрөгийг орон нутгийн нэгдсэн сангаас, 2,963,45.0 мянган төгрөгийг хандив тусламжийн орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Хөрөнгө оруулалтын 77 төсөл, арга хэмжээнд 5,649,400.0 мянган төгрөгийн санхүүжилт батлагдсанаас гүйцэтгэлээр 4,871,264.8 мянган төгрөгийг зарцуулсан байна.

2.11. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 15 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 15 эрсдэл тодорхойлж нийт 15 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 629,300.0 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс, 629,300.0 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлж, алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 1 зөвлөмж өглөө.

Аудитаар дараах 629,300.0 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил илэрснээс 629,300.0 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүллээ. Үүнд:

1. Судалгааны маягт Д301/01 болон орлогын журналыг тулган шалгахад орлогын төлөвлөгөөний биелэлт 78,0 хувьтай бөгөөд төсвийн орлогыг 629,300.0 мянган төгрөгөөр тасалдуулсан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2-д “батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих”, 41 дүгээр зүйлийн 41.2.1-д “хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна. Энэ нь Эрх ба үүрэг, Үнэн зөв байдал батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгөх

Аудитаар илэрсэн алдаа, зөрчилд 1 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

2.12. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Хандив тусламжийн орлогыг бүрэн төвлөрүүлэх тал дээр анхаарах шаардлагатай.



2.13. Шилэн дансны мэдээлэл

Дорнод аймгийн Орон нутгийн хөгжлийн сан нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллагын Шилэн дансны тухай хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

2.14. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 1 зөвлөмж өгч, хэрэгжилт 100 хувьтай байна.

2.15. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Зөрчилгүй” дүгнэлт

Аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.



Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Санхүүгийн бүртгэл, программ хангамжтай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт: Нягтлан бодох бүртгэл хөтлөлтөд санхүүгийн программ хангамж ашиглаагүй байна.

1.2. Эрсдэл: Тайланг үнэн зөв нэгтгэгдэхгүй байх, өмнөх жилүүдийн санхүүгийн мэдээллүүд хадгалагдахгүй байх.

1.3. Өгсөн зөвлөмж: Санхүүгийн программ ашиглан бүртгэл хөтлөх.

1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Өгсөн зөвлөмжийн дагуу ажиллах болно

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2020 оны 06 дугаар сарын 01-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

1.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан



Аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	154 981 140,72	630 835 843,73
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	154 981 140,72	1 535 843,73
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	154 981 140,72	1 535 843,73
3121	Төгрөг	154 981 140,72	1 535 843,73
31211	Төрийн сангийн харилцах	154 981 140,72	1 535 843,73
33	АВЛАГА	00,00	629 300 000,00
335	Бусад авлага	00,00	629 300 000,00
3351	Байгууллагаас авах авлага	00,00	629 300 000,00
3352	Хувь хүмүүсээс авах авлага	00,00	00,00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	154 981 140,72	630 835 843,73
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	00,00	379 291 337,00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	00,00	379 291 337,00
413	Өглөг	00,00	379 291 337,00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг		
4136	Бусад өглөг		379 291 337,00
41361	Байгууллагад төлөх өглөг		00,00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	00,00	379 291 337,00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	154 981 140,72	251 544 506,73
51	Засгийн газрын хувь оролцоо	154 981 140,72	251 544 506,73
512	Хуримтлагдсан үр дүн	154 981 140,72	251 544 506,73
51210	Өмнөх үеийн үр дүн	297 563 445,42	154 981 140,72
51220	Тайлант үеийн үр дүн	-142 582 304,70	96 563 366,01
51230	Давхардсан гүйлгээг цэвэрлэх данс	00,00	00,00
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	154 981 140,72	630 835 843,73

4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1 841 029 425,70	5 512 119 541,31
11	ТАТВАРЫН ОРЛОГО	00,00	00,00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	257 297 000,00	2 847 834 200,00
120	Нийтлэг татварын бус орлого	257 297 000,00	00,00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	257 297 000,00	00,00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00,00	00,00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	257 297 000,00	00,00
122	Тусламжийн орлого	00,00	2 847 834 200,00
122001	Хандив тусламж /дотоод/	00,00	2 847 834 200,00
122002	Хандив тусламж /гадаад/	00,00	00,00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1 583 732 425,70	2 664 285 341,31
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1 583 732 425,70	2 664 285 341,31
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	00,00	25 580 400,00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих		
131008	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих	1 583 732 425,70	2 638 704 941,31
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1 983 611 730,40	5 415 556 175,30
21	УРСГАЛ ЗАРДАЛ	160 000 000,00	165 000 000,00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	160 000 000,00	165 000 000,00
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	00,00	00,00
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	00,00	00,00
213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг	00,00	00,00
2132	Бусад урсгал шилжүүлэг	160 000 000,00	165 000 000,00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	00,00	00,00



Аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

213203	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	00,00	00,00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	00,00	00,00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	160 000 000,00	165 000 000,00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1 823 611 730,40	5 250 556 175,30
2200	Дотоод эх үүсвэрээр	1 823 611 730,40	5 250 556 175,30
220001	Барилга байгууламж	00,00	00,00
223001	Бусад хөрөнгө	1 823 611 730,40	5 250 556 175,30
226001	Гадаад эх үүсвэрээр	00,00	00,00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-142 582 304,70	96 563 366,01
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	00,00	00,00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	00,00	00,00
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-142 582 304,70	96 563 366,01

4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1 841 029 425,70	4 882 819 541,31
11	ТАТВАРЫН ОРЛОГО	00,00	00,00
110	Орлогын албан татвар	00,00	00,00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	257 297 000,00	2 218 534 200,00
120	Нийтлэг татварын бус орлого	257 297 000,00	00,00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	257 297 000,00	00,00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00,00	00,00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	257 297 000,00	00,00
1200043	Урьд оны үлдэгдэлээс санхүүжих	00,00	00,00
122	Тусламжийн орлого	00,00	2 218 534 200,00
122001	Хандив тусламж /дотоод/	00,00	2 218 534 200,00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1 583 732 425,70	2 664 285 341,31
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	00,00	00,00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	00,00	25 580 400,00
131008	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих	1 583 732 425,70	2 638 704 941,31
131009	Оны эхний үлдэгдлээс санхүүжих	00,00	00,00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	160 000 000,00	165 000 000,00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	160 000 000,00	165 000 000,00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	160 000 000,00	165 000 000,00
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	00,00	00,00
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	00,00	00,00
213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг	00,00	00,00
2132	Бусад урсгал шилжүүлэг	160 000 000,00	165 000 000,00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	160 000 000,00	165 000 000,00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	1 681 029 425,70	4 717 819 541,31
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	1 823 611 730,40	4 871 264 838,30
4	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)	00,00	00,00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	1 823 611 730,40	4 871 264 838,30
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1 823 611 730,40	4 871 264 838,30
2200	Дотоод эх үүсвэрээр	1 823 611 730,40	4 871 264 838,30



Аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

220001	Барилга байгууламж	00,00	00,00
221001	Их засвар	00,00	00,00
222001	Тоног төхөөрөмж	00,00	00,00
223001	Бусад хөрөнгө	1 823 611 730,40	4 871 264 838,30
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-1 823 611 730,40	-4 871 264 838,30
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	00,00	00,00
14	Бусад эх үүсвэр	00,00	00,00
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	00,00	00,00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-142 582 304,70	-153 445 296,99
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	297 563 445,42	154 981 140,72
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	154 981 140,72	1 535 843,73

4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	00,00		297 563 445,42	00,00	297 563 445,42
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00,00	00,00	00,00	00,00	00,00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	00,00	00,00	297 563 445,42	00,00	297 563 445,42
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00,00	00,00	00,00	00,00	00,00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00,00	00,00	00,00	00,00	00,00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00,00	00,00	00,00	00,00	00,00
C07	Тайлант үеийн үр дүн	00,00	00,00	-142 582 304,70	00,00	-142 582 304,70
C08	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	00,00	00,00	154 981 140,72	00,00	154 981 140,72
D01	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл			154 981 140,72	00,00	154 981 140,72
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт					
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл			154 981 140,72	00,00	154 981 140,72
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт			00,00	00,00	
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт			00,00	00,00	00,00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз			00,00	00,00	00,00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү			00,00	00,00	00,00
D08	Тайлант үеийн үр дүн			96 563 366,01	00,00	96 563 366,01
D09	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл			251 544 506,73	00,00	251 544 506,73

4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Өмнөх оны		Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1 983 611 730,40	1 983 611 730,40	5 814 400 000,00	5 036 264 838,30



Аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

21	УРСГАЛ ЗАРДАЛ	160 000 000,00	160 000 000,00	165 000 000,00	165 000 000,00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	00,00	00,00	00,00	00,00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	160 000 000,00	160 000 000,00	165000000,00	165000000,00
2132	Бусад урсгал шилжүүлэг	160 000 000,00	160 000 000,00	165000000,00	165000000,00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	160 000 000,00	160 000 000,00	165 000 000,00	165 000 000,00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1 823 611 730,40	1 823 611 730,40	5 649 400 000,00	4 871 264 838,30
2200	Дотоод эх үүсвэрээр	1 823 611 730,40	1 823 611 730,40	00,00	00,00
223001	Бусад хөрөнгө	1 823 611 730,40	1 823 611 730,40	5 649 400 000,00	4 871 264 838,30
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1 841 029 425,70	1 841 029 425,70	5 814 400 000,00	4 882 819 541,31
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1 583 732 425,70	1 583 732 425,70	1 269 565 100,00	1 269 450 615,00
131001	Улсын төсвөөс санхүүжих	00,00	00,00	00,00	00,00
131008	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих	1 583 732 425,70	1 583 732 425,70	2 825 369 600,00	2 638 704 941,31
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	00,00	00,00	00,00	00,00
132001	Орон нутгийн төсвөөс	00,00	00,00	25 580 400,00	25 580 400,00
122	ТУСЛАМЖИЙН ЭХ ҮҮСВЭРЭЭС САНХҮҮЖИХ	257 297 000,00	257 297 000,00	2 963 450 000,00	2 218 534 200,00
122001	Хандив тусламж /дотоод/	257 297 000,00	257 297 000,00	2 963 450 000,00	2 218 534 200,00
122002	Хандив тусламж /гадаад/	00,00	00,00	00,00	00,00
14	БУСАД ЭХ ҮҮСВЭР	00,00	00,00	00,00	00,00
145005	Төсөв болон дамжуулан зээлдүүлсэн зээлээс эргэж төлөгдөх	00,00	00,00	00,00	00,00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00,00	00,00	00,00	154 981 140,72
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00,00	154 981 140,72	00,00	1 535 843,73
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	00,00	00,00	00,00	00,00
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	00,00	00,00	00,00	00,00